

**2.3. НОМОНД ДУРЛАХ СЭТГЭЛИЙГ БЯСАЛГАЛААР  
БИЙ БОЛГОХ ТУХАЙ БУДДЫН ГҮН УХААНЫ СУРГААЛ  
(ЗУРГААН ХУРАН МЭДЛИЙГ ШҮТЭХ)**

Түлхүүр үг: 1. Шавь бол өвчтөн

2. Багш бол эмч

3. Ном бол эм

4. Сургалт бол эмчилгээ

5. Багшийн ном бол дээдийн сургаал

6. Багшийг ном ёсоор сонсвоос сургаал мөнхөрнө

*Товч агуулга: Аль ч номонд суралцахад шавь хүнд тавигдах шинж гэж заавал байх ёстой гээд тэрхүү шинжийг эзэмшээгүй, тийм шинж чанаргүй хүн болвоос ямар ч эрдэм ухаанд суралцах, тэгэх тусмаа тэр чиглэлээр амжилт гаргаж чадахгүй хэмээн буддын сурганд номолно. Заавал байх ёстой шинжүүдийг эзэмших арга ухаан байх агаад тэр нь юу гэвэл шавь хүн нь номонд дурлах сэтгэлийг өөртөөн бясалгалын аргаар бий болгох сургаал ном аж.*

*Савын буюу сонсохын гурван алдааг гаргахгүй байх (савын гурван гэгийг тэвчих). Сонсох эрдмийг сав суулгатай, сургаал номыг хур бороотой зүйрлэн; сонсох эрдмийг, ёсыг зөрчвөөс номонд суралцахад гарах гурван чигийн алдааны тухай энд өгүүлдэг. “Хэрэв сав ам нь түрүүлгээ харчихсан, эсвэл бохир заваан, цэвэрхэн байсан ч ёроол нь цоорхой аваас бороо орсон чиг гэсэн саванд эс орно; саванд орсон чиг түүнд эс тогтоно, тогтсон чиг гэсэн борооны ус уухын аргагүй заваан юм болно”<sup>1</sup>. Дээрхийн адилаар бурханы ном сурахаар сургуульд суусан хэдий ч, хэрэв багшийн заасныг анхааралтай эс сонсвоос, сонссон чиг гэсэн утга агуулгыг буруугаар ойлговоос, эсвэл буруу санаа бодлыг агуулан сонсвоос; эсвэл дээрх гурван чигийн алдаа гаргахгүй юмаа гэхэд сонссон дуулснаа эс тогтоовсоос, тогтоосон чиг тэр дороо мартваас, мартаагүй чиг гэсэн түүндээ ач холбогдол эс өгвөөс багшийн номыг сонссоны хэрэг гарахгүй. Тийм болохоор савын гурван гэгийг, сонсохын гурван алдааг гаргахгүй байвал зохино. “Бүхнийг мэдэж авахын тулд, анхаарлаа дээд зэргээр төвлөрүүлэн, сэтгэлээ дээд зэргээр гарган, бодлоо дээд зэргээр дайчлан сонсох хэрэгтэй” хэмээн<sup>2</sup> “Их бодь мөрийн зэрэг”-т сургасан байна. Энэ бол ямар ч түүхэн эрин үед, ямар ч улс үндэстэнд, багшаар ном заалгаж байгаа ямар ч хүнд,*

шавьд тавигдах ёстой, тавигддаг нийтлэг, түгээмэл шаардлага мөн байх; орчин цагийн европын судалгаанд мөн адил. *Шавь нарт 6 чигийн сэтгэл, тэмүүллийг бий болгох нь*. Дээр өгүүлсэн 3 чигийн гэм, алдааг гаргахгүй, гаргуулахгүй байхын тулд шавь нарт дараах 6 чигийн сэтгэл, тэмүүллийг бий болгох ёстой аж<sup>3</sup>. Үүнд:

1. Өөрийгөө эрдэм ухааны дутагдалд орж өвдөн шаналж байгаа хүн хэмээн сэтгэн бясалгах

2. Багшийгаа авралт эмч хэмээн сэтгэн бясалгах

3. Багшийн сургаал номыг өвчнийг анагаах эм хэмээн сэтгэн бясалгах

4. Ном сурахыг эмчилгээ хэмээн сэтгэн бясалгах

5. Багшийн номлосон сургаалыг дээд хүний сургаал хэмээн сэтгэн бясалгах

6. Бурханы сургаалыг ёс номоор нь сонсвоос уг сургаал өнө удаан оршино хэмээх сэтгэлийг өөртөө төрүүлэх.

1. Өөрийгөө өвчтөн хэмээх сэтгэлийг өөртөөн төрүүлэх (өөртөөн өвчтөн мэтийн хуран мэдлийг агуулах). Шавь эхлээд өөрийгөө эдгэшгүй хүнд өвчнөөр байнга өвдөж, зовж шаналан, үе үе тэсэхийн аргагүй зовиурлан, дуу алдан зовно, улмаар тарчлах маягтай болно хэмээн яг өөр дээрээ болсон юм шиг, одоо ч тийм байгаа юм шигээр төсөөлөн бодно, сэтгэнэ; сэтгэлд буун буутал, айдас төрөн төрөх хүртэл дахин дахин бодно; сэтгэнэ, төсөөлнө; бясалгана. Өвдөх нь нэн аймшигтай, зовиуртай, зовлонтой хэмээх сэтгэл баттай төрсний дараа, тэрхүү өвчин нь муу сэтгэл, нисванисаас бий болдог; хүн атаа жөтөө, хор шар, үзэн ядах, шунах зэрэг ухааны жолоодлогогүй сэтгэлээс болж дээрхийн нэгэн адил зовлонд унаж энэлэн шанална; тэсэж тэсвэрлэхийн аргагүй зовиурлана, сэтгэлд мөнхийн мэт санагдах дарамтанд орно; бүх юм үүгээр дуусах мэт бодогдоно; ер нь тэгэх чиг байх хэмээх айдас төрөн төртөл, энэ бүхнийг дахин дахин өөртөө хэлж, дахин дахин бодно, сэтгэнэ; энэ бүхэн буун, улмаар тогтон тогтол нь дээрх аргаар бясалгал хийнэ; ингэснээр өвчнөө эмчлүүлэх, зовлонгоос хагацах сэтгэл, тэмүүлэл бий болж, улмаар эрч хүчээ авна. Тэрхүү сэтгэл, тэмүүлэл гэдэг нь эмчид үзүүлэх, эм олж уух буюу зовлонгийн шалтгаан болох мунхагийн харанхуйгаас гаргадаг багшийн сургаалыг сонсохын хүслэнг хэлнэ. “Хэрвээ чи өөрийгөө үнэхээр өвчинд баригдсан хүн шигээр төсөөлөн, түүнээс болж энэлэн шаналах сэтгэлийг өөртөөн сайтар төрүүлж чадаагүй аваас бясалгалыг буруу хийлээ гэж ойлго. Би хэмээх зөвхөн өөрийгөө, хар амиа бодох, уурлах, мунхаглах гэсэн гурван төрлийн муу сэтгэлийн халдварт, архагшсан өвчнөөр нэн хүнд өвчилчихөөд байна гэдгээ чи мэдэхгүй байна гэсэн үг”<sup>1</sup> хэмээн Богд Зонхов сургасан

---

байна. Ийм тохиолдолд хэрэв бясалгалыг дахин зөв хийхгүй аваас шавь нарт эрдэмд тэмүүлэх сэтгэл бий болохгүй. Тэд мунхагийн харанхуйгаас салж чадахгүй болно.

2. Багшийгаа авралт эмч хэмээх сэтгэлийг төрүүлэх (ном өгүүлэгч дор эмч мэтийн хуран мэдлийг үүсгэх). Өвчиндөө энэлэн шаналж, байж суухын аргагүй болсон хүн ямар ч хамаагүй аргаар, ямар ч хамаагүй үнээр өвчнөөс салахын, өвдөлтийг нь намдаах бараг юунд ч үл дийлдэх сэтгэл, тэмүүлэлтэй болно. Энэ үед авралт эмчээс өөр хүн түүнд тусалж эс чадна гэсэн сэтгэлийг өөртөө дахин дахин бясалган байж бий болгоно. Түүний дараа тэрхүү өвчнөө сэтгэлийн бузраас болсон зовлон хэмээх аюулт өвчин, түүнээс зөвхөн ачит багш, түүний сургаал ном л аврана хэмээн дахин дахин бодно, тийм сэтгэлийг төрөн төртөл, төрсөн тэр сэтгэлийг тогтон тогттол уг бодлоо, бясалгалаа үргэлжлүүлнэ. Энэ бол багшаа шүтэн бишрэх, хүндлэн дээдлэх сэтгэл аж. “Ингэхлээр хэн ухаарч, гэгээрэхийг үнэхээр хүснэв, бардам зангаа тэр дор нь даран авч авралт номын багшийг эрж ол, тэрээр эмч лугаа адил чамайг зовлонгоос чинь салгаж өгнө”<sup>2</sup>.

3. Багшийн сургаалыг өвчнийг анагаах эм мөн гэсэн сэтгэлийг төрүүлэх (дагуулан үзүүлсэнд эмийн хуран мэдлийг үзүүлэх). Зөвхөн авралт мэргэн эмчийн зааврын дагуу, түүний эмийг ууваас аюулт өвчнөөсөө сална, тэсвэрлэхийн аргагүй аймшигт өвдөлт намдана, намдаж байна гэсэн бодлыг дахин дахин төрүүлж, энэ чигийн сэтгэл төрөн төртөл нь, төрсөн нь тогтон лавширтал нь дасгал, бясалгалыг үргэлжлүүлнэ. Өвчин, өвдөлт гэдэг нь нисванис, муу сэтгэл, ялангуяа мунхагийн харанхуй, өөрийгөө бусдаас дээгүүр тавих “би” хэмээх сэтгэлийн бузар аж. Зөвхөн багшийн сургаал хэмээх эмийг, түүний заавраар ууваас, сонсвоос сэтгэлийн зовлон хэмээх тэрхүү аймшигт өвчнөөс сална, салж байна гэсэн сэтгэлийг өөртөө төрүүлнэ, тэгснээр эм өвчтөний сэтгэлийг өөрийн эрхгүй татдагийн адил багшийн ном сургаал шавийн сэтгэлийг татна, шавьд тэрхүү сургаалыг сонсох хүсэл эрмэлзэл, тэмүүлэл өөрийн эрхгүй ундрэн бий болно. Өвчтөн хүн эмчийн бичиж өгсөн эмийг, түүний зааврыг хэрхэн чанд баримтлан уухтай адил багшийн айлдсан, заасан сургаалыг ёсчлон сурч, сурсныгаа мартажгүй, орхихгүй байвал зохилтой<sup>1</sup> байх юм.

4. Номонд суралцахыг эмчилгээ лугаа мэдрэх сэтгэлийг бий болгох (шамдлаар анхааран авсанд өвчин илааршихын хуран мэдлийг үүсгэх). Хичнээн ч сайн эмчийн тогтоосон, хичнээн ч оносон оношилгоотой байлаа ч тэрхүү эмчийн бичиж өгсөн хичнээн ч сайн эм, түүнийг уух хичнээн ч сайн заавар журам байлаа ч тэдгээрийг үл ойшоовоос, тухайн тохиолдолд эмчилгээг ёс номоор нь эс хийвээс тэр хүн өвчнөөсөө

салж, өвдөлтийг намдааж эс чадна. Эмчилгээг зөвхөн эмчийн зааврын дагуу хийж байж л намайг тарчлаагч тэр аймшигтай өвчин, өвдөлт шаналгаанаас салж чадна хэмээх сэтгэлийг шавь хүн өөртөө бясалгал хийх арга ухааны дагуу сайтар хийж бий болгоно. Дараа нь хичнээн ч сайн эрдэмтэн багштай, багшаасаа хичнээн ч сайхан мэргэн сургаал сонслоо ч, түүнийг өөрийн амьдралд, сэтгэлийнхээ бузрыг арилгахад хэрэглэж эс чадна; ингэхийн тулд номонд тэмүүлнэ, багшийн заасан эрдэм ухаанаар сэтгэлийн бузраа арилгах, сэтгэлийн хөдөлгөөнөө жолоодох бясалгалыг уйгагүй сайн эс хийх ёстой, эс тэгвээс би зовлонгоос салж, түүнийг нимгэлэн жаргалд хүрч хэзээ ч чадахгүй гэсэн сэтгэлийг өөртөө сайтар төрүүлж, бататган тогтоож чадваас номонд дурлах сэтгэл улам илүү лавширна, ном сонсох нь практик үр өгөөжтэй чиг болно. “Хэрэв эмчийн бичиж өгсөн эмийг эс ууваас, эсвэл өөр эм ууваас өвчин хэзээ ч эдгэрэхгүйн адил багшийн сургаал, айлдварыг биелүүлэхгүй аваас шавь хэзээ ч сэтгэлийн бузраас салж чадахгүй; тийм болохоор сургаалыг өөрийн болгон гэгээрлийг олохын тулд бясалгалын дасгалыг цуцалтгүй хий; амьдрал практикт хэрэглэхгүй юм бол онолын мэдлэгийг хичнээн ч хураагаад нэмэргүй”<sup>2</sup>. Багшийн сургаалыг нэн сайн сонсож, нэн сайн мэдэж байж түүнийг амьдралд хэрэгжүүлэх бясалгалын дасгал сургуулийг хийвээс тэр сая үр дүнд хүрнэ; сургаалыг тааруухан сонсож, дульхан ойлгоцтойгоор бясалгалыг хичнээн сайн үйлдлээ гэхэд, шавь хүн сэтгэлийнхээ бузраас тэглээ сайн салж, зовлонгоо нимгэлж, буян хурааж, сайн үйл бүтээдэггүй аж.

5. Багшийгаа дээд төрөлхтөн, сургаалыг нь дээд төрөлхтнийх хэмээх сэтгэлийг өөртөөн төрүүлэх (Түүнчлэн ирсэн дор дээд төрөлхтний хуран мэдлийг агуулах). Энэ нь, хэрэв багшийгаа дээд төрөлхтөн, сургаалыг нь тэрхүү төрөлхтний ном, эрдэм хэмээх сэтгэлийг өөртөө бий болгосон тэр цагт багшийн эрдмийг сонсвоос шавь илүү ихээр ухаарна, гэгээрнэ гэсэн үг. Хүндэтгэл, дээдлэлээс ном эрдэмд тэмүүлэх эрч хүчийг авна. Ер нь чиг бурханыг, тэгээд ч дунд, дээд хөлгөний ном, сургаал зааж буй багш хүн дээд төрөлхтөнд багтахаас өөр яахав

6. Өвчтөнд эм болдог бурхан багшийн сургаал өнө удаан жил оршин тогтноно, тэгэхээр тэрхүү эмийг ууж, сургаалыг хүргэж, тэгснээрээ өвчнөөсөө салах, зовлонгоос хагацах бололцоо он удаан жилийн настай хэмээх сэтгэлийг өөртөө төрүүлэх (номын ёс өнө удаан жил орших). Багшийн сургаалыг сонсох талаар дээр өгүүлсэн төгөлдөр сургаал байх хэдий ч тэрхүү сургаалыг сонсоод сонсоод сэтгэлдээ эс буулгаваас, ухаандаа эс тунгааваас тэр нь эм ч болохгүй, багш эмч болж чадахгүй, сурах нь эмчилгээ ч болохгүй, өөрөө өвчнөөс, зовлонгоос үл сална. “Багшийн сургаалыг

номлож, сонсож байгаа хэдий ч өөрөө түүний агуулгаас хол хөндий байваас түүний агуулга хичнээн зөв байлаа ч шавийн сэтгэлд үл бууна, зүрх сэтгэлд үл хүрнэ. Тийм болохоор багшийн сургаалыг өөрийгөө, өөрийн сэтгэлийг бузрыг арилгана гэсэн хатуу бодол өвөрлөн сонсох хэрэгтэй. Зүйрлэвээс нүүр ам бохир, халтар байна уу, үгүй юу гэдгийг толинд харан мэдсэнээр түүнийг арилгадагтай адилаар багшийн сургаал толинд, уг сургаалыг сонсох явцад өөрийнхөө үйлийн сайн, мууг харна; тэгээд “би ч ийм амьтан юм даа” гэсэн сэтгэлийн зовлон төрнө; түүний мууг нь арилгах, сайныг нь сургаал ном ёсоор арвижуулна”<sup>1</sup> хэмээн “Их бодь мөрийн зэрэг”-т өгүүлсэн байна. Багшийн сургаалыг сонссон чиг тогтоохгүй, тогтоосон чиг өөр утга агуулгатай болгочихсон; тогтоосон чиг нэг их удахгүй мартваас сонссоны үр дүн гэж огт гарахгүй; шавь хэзээ ч ухаарлыг эс олно, өөрийн гэсэн мэдлэгтэй, итгэл үнэмшилтэй болж чадахгүй; гэгээрлийг эс олно, өөрийнхөө сэтгэлийн хөөрөл, хөдөлгөөнийг залж жолоодож, ажил амьдралаа зөв замд оруулж эс чадна; буддын гүн ухааны хэлээр бол тийм шавь зовлонт амьдралаар энэ насыг барна, жаргалантай сайхныг эс үзнэ. Европын сурган хүмүүжүүлэх ухаанд ч гэсэн асуудлыг дээрхийн нэгэн адилаар авч үзэх болов уу. Шавь нар багшийн лекцийг сонссон чиг гэсэн түүний агуулгыг гуйвуулан буруугаар ухаарсан; тэрхүү агуулгыг зөв ч бай, буруу ч бай тогтоосон чиг гэсэн түүнийг нэг их удахгүй ор тас мартчихваас; тэр шавийг мэдлэгтэй, боловсролтой гэхийн аргагүй; тийм шавь орчинтойгоо буруугаар харьцана, алдана; мөнхийн бэрхшээл зовлонтой тулгарна; ажил амьдрал нь эцэс төгсгөлгүй уруудна; “буруу замаар будаа тээвэл буцаад ирэхдээ шороо тээнэ” гэдэг болно. Буддын сургаалын “сонсох ёс” хэмээх сургаал нь орчин цагийн сурган хүмүүжүүлэх практикт нэн хэрэгтэй, онолын агуулгыг баяжуулахад бас тустай байхаар юм. Хичээлийн агуулга нь сонгодог шинжлэх ухаан, заадаг багш нь түүнийг төгс эзэмшсэн байх нөхцөлд шавь нарт дээр өгүүлсэн сонсох эрдмийг, зургаан чигийн сэтгэлийг бясалгалын аргаар төрүүлж чадваас, тэднийг дахин дахин шахаж шаардахын хэрэггүй; тэд ном эрдэм сурах ажилд өөрийн бүхий л оюун ухаан, сэтгэл санаа, биеийнхээ эрч хүч, энергийг дээд зэргээр дайчлан ороод явчих нь. Сурган хүмүүжүүлэх ухааны хөгжлийн хэтийн төлөв, ирээдүй гэвэл өрнийн сурганы ухааныг буддын сурганы онол, практикаар баяжуулж, тэдгээрийг өөр хооронд нь шүтэн барилдуулсан, синтезлэсэн цоо шинэ маягийн сурган байхаар төсөөлөгдөнө; хүн төрөлхтний соёл иргэншил Дорноос эх авч, Өрнөөр дамжин, эргээд Дорно дахинд ирнэ, гэхдээ тэр нь Өрнө, Дорно хоёр синтезлэгдэх, шүтэн барилдах ерөнхий зүй

---

тогтол бий. Хаана энэ зүй тогтлыг цагаас нь түрүүлэхгүй, мөн цаг алдалгүй хэрэгжүүлнэ, тэнд тухайн юмны хөгжил зөв замаар, эрчимтэй урагш ахина. Өрнө, Дорнын сурган хүмүүжүүлэх ухааны онол сургаал өөр хоорондоо шүтэн барилдаж, нийтлэг шинжтэй нэдмэл нэгэн ухаан болох үйл явц ч мөн л тэр зүй тогтлоор явагдана.

#### Резюме

В Буддизме имеется тончайшим образом разработанная методика привития к учащимся склонности любви к учебе, учению путём медитации. В буддизме имеется, так называемая область знания "Винай" (буддийская педагогика), где рассматривается педагогическое учение, истинность которого проверена на практике в течении многих тысяч лет и в настоящей статье речь идёт об этом учении.

#### НОМ ЗҮЙ

1. Чже Цонкапа. Большое руководство к этапам пути пробуждения. Т.1, СПб.,1994
2. Н.Хавх. Буддын сурган, сэтгэл судлал. Хүмүүжлийн гүн ухаан. УБ.,2006
3. Богд Зонхов. Бодь мөрийн зэрэг. Корея.,2002